

Хүний хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн (Эрүүл мэнд), М Нандинцэцэг

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг улс, бүс, орон нутаг, салбар хоорондын уялдааг ханган боловсруулах, хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төлөвлөлтийг хийх, хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах, нэгдсэн бодлогыг тодорхойлох;							
1	“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулна.	Боловсруулах төлөвлөлтийн баримт бичгийн тоо	Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” -ийг батлуулсан.	“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. /1 төлөвлөлтийн баримт бичиг/	“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлууллаа. Уг төлөвлөлтийн баримт бичгийг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан судалгаа, шинжилгээнд тулгуурлан, зорилго, зорилт нь хэмжигдэхүйц, шалгуур үзүүлэлт нь зорилгодоо нийцсэн, төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байдлаар бүх талын оролцоог хангаж, нийт 40 төсвийн ерөнхийлөн захирагчтай хамтран боловсрууллаа. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төслийг боловсруулахдаа нийт 14 удаагийн олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, Шинжлэх ухааны академийн Бага болон Их чуулганаар хэлэлцүүлсэн нь шинжлэх ухаанд суурилсан бодлого боловсруулахад онцгой ач холбогдолтой болсон. Олон нийтийн хэлэлцүүлэгт шүүх засаглалын байгууллага, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллага, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын албан хаагчид, иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл оролцож, нийт 644 санал гаргаснаас хуульд тогтоомжийн дагуу үндсэн чиглэлийн төсөлд тусгасан болно. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төсөл нь “Шинэ итгэл-Эрс шинэчлэл”-д зорин “Хүний хөгжил”, “Нийгмийн хөгжил, үндэсний нэгдмэл үнэт зүйл”, “Эдийн засаг, дэд бүтцийн хөгжил”, “Байгаль орчин, ногоон эдийн засаг”, “Төрийн	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					бүтээмж, засаглал", "Бүсийн хөгжил", "Үндэсний өрсөлдөх чадвар", "Шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун" гэсэн бодлогын 8 чиглэлээс бүрдэх бөгөөд энэ хүрээнд Үндэсний, Салбарын, Төсвийн ерөнхийлөн захирагчийн, Хөтөлбөрийн гэсэн 4 түвшний үр дүнг, тэдгээрийг хэмжих шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлсон.		
2	"Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний төслийг боловсруулна.	Боловсруулах төлөвлөлтийн баримт бичгийн тоо	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолын хавсралтаар "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-г батлуулсан.	-	"Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулна. Уг төлөвлөгөө нь "Хүн төвтэй" хөгжлийн үзэл санаанд нийцсэн "Эдийн засгийн эрх чөлөөг цогцлоох"-ыг зорьж, эдийн засгийн эрх чөлөөний реформ, төсвийн зардлын реформ, төрийн албаны реформ, үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн засаглалын реформыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тус төлөвлөгөөнд "Бүсчилсэн хөгжлийн бодлого", "Хүний хөгжлийн бодлого", "Эдийн засгийн бодлого", "Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого" гэсэн дөрвөн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, нийтдээ 18.9 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 330 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх юм. "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө" нь үр дүнд суурилсан төлөвлөлтийн зарчимд суурилсан, урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй бүрэн уялдсан төлөвлөлтийн баримт бичиг болсон юм.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%
3	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлж улс, бүс, орон нутаг, салбар хооронд нэгтгэн зохион байгуулах, уялдааг хангах, арга зүйн зөвлөгөө өгнө.	Арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байх, хувиар	-	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. /100 хувь/	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлж, улс, бүс, орон нутаг, салбар хооронд нэгтгэн зохион байгуулж, уялдааг хангаж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар батлуулсан бөгөөд Монгол Улсын хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл нь "Хүн төвтэй" хөгжлийн үзэл санаанд нийцсэн "Эдийн засгийн эрх чөлөөг цогцлоох"-ыг зорьж, энэ хүрээнд "Бүсчилсэн хөгжлийн бодлого", "Хүний хөгжлийн бодлого", "Эдийн засгийн бодлого", "Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого" гэсэн бодлогын 4 тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Мөн "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн батлуулна. "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн төсөл нь "Шинэ итгэл-Эрс шинэчлэл"-д зорин "Хүний хөгжил", "Нийгмийн хөгжил, үндэсний нэгдмэл үнэт зүйл", "Эдийн засаг, дэд бүтцийн хөгжил", "Байгаль орчин, ногоон эдийн засаг", "Төрийн бүтээмж, засаглал", "Бүсийн хөгжил", "Үндэсний өрсөлдөх чадвар", "Шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун" гэсэн бодлогын 8 чиглэлээс бүрдэх бөгөөд энэ хүрээнд Үндэсний, Салбарын, Төсвийн ерөнхийлөн захирагчийн, Хөтөлбөрийн гэсэн 4	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					түвшний үр дүнг, тэдгээрийг хэмжих шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлсон. Түүнчлэн, Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/13 тушаалаар “Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал”-ыг баталсан бөгөөд түүнийг танилцуулах 2 удаагийн сургалтыг 21 аймаг, нийслэлийн төлөвлөлтөд оролцож буй албан хаагчдад зохион байгуулж, уялдааг хангаж, арга зүйн зөвлөгөөг өгч ажиллалаа. Нийт 480 оролцогчид хамрагдсан.		
4	Нийгмийн тогтвортой хөгжлийн бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангана.	Бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангасан байх, хувиар	-	Бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангасан байна. /100 хувь/	Нийгмийн тогтвортой хөгжлийн бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллав. Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-г хэлэлцүүлэн батлуулсан. Энэ хүрээнд боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бүлэг дүүргэлтийг стандарт хэмжээнд хүргэх, сургуулийн хүртээмжийг сайжруулах “Хамгийн сайн цэцэрлэг, сургууль – гэрт ойр” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгав. Мөн “Эрүүл Монгол хүн” зорилтын хүрээнд эрүүл мэндийн шинэ технологи нэвтрүүлэх, санхүүжилтийн тогтолцоо- сайжруулах; түүнчлэн хүүхэд хамгаалал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчилгээ, зорилтот өрх, иргэдийг бие даасан амьдралд дэмжих хүн төвтэй нийгмийн үйлчилгээ-г хөгжүүлэх нийгмийн тогтвортой хөгжлийн бодлогыг тодорхойлж төлөвлөлтөд тусгав. Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар батлагдсан “Монгол Улсыг 2026–2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д 8 бодлогын чиглэлийн хүрээнд 10 үндэсний үр дүн тодорхойлсон. Хүний хөгжил, нийгмийн хөгжлийн чиглэлээр дараах зорилтуудыг дэвшүүлэв: Боловсролын чанар, хүртээмжийн ялгааг арилгах, Эрүүл мэндийн тогтолцооны гүйцэтгэлийг тодорхой түвшинд хүргэж, иргэн бүрт тэгш, чанартай, санхүүгийн эрсдэлгүй тусламж үйлчилгээ хүргэх; дундаж наслалтыг 2 жилээр нэмэгдүүлэх, Хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцсэн хүний нөөц бэлтгэж, хүний хөгжлийн индексийг 0.756-аас 0.85 болгох, Зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, дундаж давхаргын эзлэх хувийг 2030 он гэхэд 20 хувиар өсгөх, Эрүүл, аюулгүй орчин, хүртээмжтэй орон сууц, чанартай нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлж, хүний эрхийг ханган, хүүхэд хамгааллыг шинэ шатанд хүргэж нийгмийн сайн сайхан байдлын үзүүлэлтийг анх удаа тооцож, 20 хувиар өсгөхөөр тусгасан. Эдгээр бодлогын зорилтын шалгуур үзүүлэлтүүдийг НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтын (SDG) үзүүлэлтүүдтэй уялдуулан тодорхойлов.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
5	Хүн амын өсөлтийг	Бодлогыг тодорхой	-	Бодлогыг тодорхойлж	Хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, мэргэжил, арга	1-р сар, 2-	100%

26

	<p>дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, мэргэжил, арга зүйгээр хангана.</p>	<p>лж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангасан байх, хувиар</p>		<p>ж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангасан байна. /100 хувь/</p>	<p>зүйгээр хангаж ажиллав. Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-г хэлэлцүүлэн батлуулсан. Энэ хүрээнд боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бүлэг дүүргэлтийг стандарт хэмжээнд хүргэх, сургуулийн хүртээмжийг сайжруулах “Хамгийн сайн цэцэрлэг, сургууль – гэрт ойр” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгав. Мөн “Эрүүл Монгол хүн” зорилтын хүрээнд эрүүл мэндийн шинэ технологи нэвтрүүлэх, санхүүжилтийн тогтолцоог сайжруулах; түүнчлэн хүүхэд хамгаалал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчилгээ, зорилтот өрх, иргэдийг бие даасан амьдралд дэмжих хүн төвтэй нийгмийн үйлчилгээ-г хөгжүүлэхээр хүний хөгжил, хүн амын өсөлтийн бодлогыг тодорхойлж төлөвлөлтөд тусгав. Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар батлагдсан “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд бодлогын 8 чиглэлийн хүрээнд үндэсний 10 үр дүнг тодорхойлсон. Хүн амын өсөлтийг дэмжих хүрээнд эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг сайжруулах, гэр бүлийн тогтвортой байдлын талаарх бүх нийтийн мэдлэг, ойлголтыг сайжруулах, халамжийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг сайжруулах, өрхийн бодит орлогыг нэмэгдүүлэх, орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зэрэг зорилт тавьсан болно. Ингэснээр хүн амын өсөлтийг одоогийн 1.1 хувийн өсөлтөөс бууруулахгүй байх бодлогыг баримталж Үндсэн чиглэлд тусгасан.</p>	<p>р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар</p>	
6	<p>Олон улсын хөгжлийн туршлага, чиг хандлагыг судалж, өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар судалж, боловсруулна.</p>	<p>Олон улсын хөгжлийн туршлага, чиг хандлагыг судлах, хувиар</p>		<p>Олон улсын хөгжлийн туршлага, чиг хандлагыг судалсан байна. /100 хувь/</p>	<p>Монгол Улсын дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлт, бүс, орон нутаг, салбар хоорондын уялдааг тоон утгаар чанаржуулах цогц судалгаа хийх зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг батлуулж ажилласан. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад бүс, орон нутгийн онцлогт нийцүүлсэн, салбар болон салбар хоорондын уялдааг хангасан тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц, бодитой, хугацаатай эерэг өөрчлөлтүүдийн талаар нарийвчилсан тооцоо, судалгаа хийх зайлшгүй шаардлага бий болсон. Дээрх цогц судалгааны ажлын хүрээнд: -Монгол Улсын дунд хугацааны бодлого, төлөвлөлт, бүс, орон нутаг, салбар хоорондын уялдааг тоон утгаар чанаржуулах цогц судалгаа хийхийн тулд олон төрлийн өгөгдлүүд, загвар ашиглах; -Уялдаа холбоотой системүүдийн хөгжлийг загварчлах, орон нутаг болон салбар хоорондын харилцан үйлчлэлийг харах зорилгоор Системийн динамик (System Dynamics) загвар ашиглах; -Орон нутаг, салбар хоорондын өөрчлөлтүүдийн нөлөөг тооцоолох Динамик симуляц ашиглах зэрэг хөгжлийн загваруудыг хөгжүүлэх юм.</p>	<p>5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар</p>	100%

27

7	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдсэн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээллийг эргэлтэд оруулна.	Хэрэгжилтийн явц, хувиар	Хэрэгжилтийн явц, хувиар	Улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сан байгуулах асуудлыг судалсан байна. /100 хувь/	Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 76 дугаар тогтоолоор Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан байгуулахаар шийдвэрлэсэн. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт " Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулан зохицуулах зорилгоор мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, эрхлэн хөтөлнө." гэж заасны дагуу Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах Ажлын хэсгийг байгуулж байна. Тус Ажлын хэсэг нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан, Аж үйлдвэрийн орон зайн төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах үйл явцыг удирдан зохион байгуулах, холбогдох байгууллагуудын мэдээллийн урсгалын нэгтгэл, харилцан уялдааг сайжруулах, мэдээллийн сангийн ашиглалтыг нэмэгдүүлэх үүрэгтэй болно. Энэхүү ажлын хэсэг нь төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний дагуу ажиллаж байгаа бөгөөд энэхүү төлөвлөгөө нь 2028 онд бүрэн хэрэгжиж дуусна.	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	90%
8	Монгол Улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгнө.	Монгол Улсын төсвийн төсөлд зөвшөөрөл өгсөн байх, хувиар	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар 2024 онд	Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд нийцсэн эсэхийг нягтлан шалгаж, зөвшөөрөл өгсөн байна. /100 хувь/	. Монгол Улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар 2025 оны 01/2244 дугаар албан бичгээр зөвшөөрөл өгч ажиллав. Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх", 27 дугаар зүйлийн 27.1.8-т "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх" гэж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3-т "улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх; гэсэн шаардлагыг ханган боловсруулж төлөвлөлт, төсөвлөлтийг уялдуулж ажилласан. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.4.3-т заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн яамнаас улсын төсвийн төсөлд зөвшөөрөл өгөхөд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ болон төсвийн төслийн уялдааны нийцэл 2022 онд 36.1 хувь, 2023 онд 47.1 хувь, 2024 онд 71.0 хувь, 2025 онд 92.0 хувь болж нэмэгдсэн байна.	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

			зөвшөөрөл өгсөн.				
9	Эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэл болон эдийн засагт тулгарч болзошгүй эрсдэлт нөхцөл байдлыг тодорхойлох хүрээнд салбаруудын мэдээллийн бааз суурийг бэхжүүлж, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллана.	Бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, салбаруудад бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан байх, хувиар	-	Бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, салбаруудад бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан байна. /100 хувь/	Эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэл болон эдийн засагт тулгарч болзошгүй эрсдэлт нөхцөл байдлыг тодорхойлох хүрээнд салбаруудын мэдээллийн бааз суурийг бэхжүүлж, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллана. Эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэл болон эдийн засагт тулгарч болзошгүй эрсдэлт нөхцөл байдлыг тодорхойлох хүрээнд салбаруудын мэдээллийн бааз суурийг бэхжүүлж, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллана. Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусган ажиллалаа. Монгол Улсын Үндсэн хуулийн 5.1 дэх хэсэгт "Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна." хэмээн заасан байдаг. Монгол Улсын нийт эдийн засгийн 93.0 хувийг уул уурхайн салбар бүрдүүлдэг. Уул уурхай дотроо нүүрс дангаараа 60.0 хувийг эзэлж байгаа ба уул уурхайн салбараас хэт хамааралтай тул дэлхийн зах зээлийн түүхий эдийн хэлбэлзлээс өндөр хамаарч, макро тогтворгүй байдал өндөр байна. Эдийн засгийн өсөлт цар тахлын улмаас 2020 онд 4.4 хувиар агшаад байсан бол 2021 онд ердөө 1.4 хувиар өсөж сэргэсэн бол 2024 онд 5.1 хувьд хүрч өссөн байна. Хөдөө аж ахуйн салбарын сэргэлт эдийн засгийн өсөлтийг дэмжиж байгаа бол уул уурхайн салбарын өсөлт удааширч, тээвэр, худалдааны салбарууд агшиж, өсөлтийг сааруулсан байна. Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэрлэсэн дүнгээр 80 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 13.5 хувиар, бодит дүнгээр 32 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 4.9 хувиар тус тус өслөө. Нэг хүнд ногдох ДНБ-ийг авч үзвэл 2020 онд 4,128.0 ам доллар байсан 2024 онд 6,898.0 ам доллар буюу 1.7 дахин нэмэгдсэн байна. Манай улсын хувьд эдийн засгийг төрөлжүүлж, уул уурхайгаас хамаарал багатай, тогтвортой өсөлттэй бүтэц рүү шилжих шаардлага байна. Иймд боловсруулах үйлдвэр, уул уурхай, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, санхүү, эрчим хүч, зам тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны салбарыг төрөлжүүлэн хөгжүүлж, экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон инновацыг дэмжих замаар дотоод нөөц бололцоог өргөжүүлэх бодлогыг "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусган төлөвлөсөн.	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
10	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийх мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэлтгэх,	Хүний нөөцийг чадавхжуулах сургалт зохион байгуулсан байх, хувиар	Хүний нөөцийг чадавхжуулах сургалт зохион байгуулсан.	Хүний нөөцийг чадавхжуулах сургалт зохион байгуулсан байна. /100 хувь/	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах ажлыг тасралтгүй хэрэгжүүлж ажиллав. Тухайлбал, Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгаж, төрийн албан хаагчдын тоог (багш, эмч нараас бусад) 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэх, төрийн байгууллагуудын чиг үүрэгт иж бүрэн шинжилгээ хийсний үндсэн дээр зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх замаар төрийн бүтээмжийг дээшлүүлж, төрийн худалдан авалтад хиймэл оюуныг ашиглан ил тод байдлыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх талаар тооцоо, судалгаа хийв. Мөн Монгол Улсын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар	100%

	чадавхжуулах ажлыг зохион байгуулна.				хэмжээнд цогц үйлчилгээний төвүүдийг байгуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх талаар судалгаа хийлээ. Хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр дараах сургалтыг зохион байгууллаа. Үүнд: -"Олон хэвт эдийн засаг, суртахууны эдийн засаг" сэдэвт сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр яамны албан хаагчдад зохион байгуулав. -Эдийн засаг, хөгжлийн яамнаас "Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний төслийн олон талт хэлэлцүүлгийг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж, тус хэлэлцүүлэгт эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн 90 гаруй хүн оролцож, 40 гаруй санал гаргалаа.-Мөн Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран "Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний төслийн талаар олон талт хэлэлцүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр амжилттай зохион байгуулж, тус хэлэлцүүлэгт хувийн хэвшил, бизнесийн байгууллага болон мэргэжлийн холбоодын төлөөлөл оролцож, 20 гаруй санал гаргалаа. "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн төслийг боловсруулахдаа нийт 14 удаагийн олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, Шинжлэх ухааны академийн Бага болон Их чуулганаар хэлэлцүүлээ.	сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
11	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, санал өгнө.	Мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, санал өгсөн байх, хувиар	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, санал өгсөн.	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, санал өгсөн байна. /100 хувь/	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж санал өгч ажиллав. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.14, 9.10.1 дэх заалтад заасны дагуу Улсын Их Хурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд суурилан тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгаж аймаг, нийслэлийн Засаг даргаас боловсруулсан Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг батлагдсан аргачлал, зааврын дагуу бодлогын баримт бичгийн уялдааг ханган үр дүнд суурилсан зарчмыг баримтлан боловсруулагдсан эсэхэд санал хүргүүллээ. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Дундговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг нийслэл, 1᠙ аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд санал, зөвлөмж хүргүүлж мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан.	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
12	Хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай	Хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд	-	Хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд	Хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай технологийг судаллаа. Хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай технологийн чиглэлүүдийг тодорхойлох судалгаа хийж, бодлогын хэрэгжилтийн мониторинг, индикатор тооцооллыг автоматжуулах дижитал шийдлийн "AI machine	10-р сар, 11-р сар,	100%

	технологи судална.	лэхэд шаардлагатай технологи и судалсан байх		шаардлагатай технологи судалсан байна. /100 хувь/	learning” талаар зөвлөх үйлчилгээ авч, гэрээгээр гүйцэтгүүлж байна.	12-р сар	
13	Салбаруудын хөгжлийн бодлогыг орон зайн судалгаанд суурилан тодорхойлох, орон зайн төлөвлөлтийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлсэн байна.	Орон зайн мэдээллийн нөхцөл байдлын үнэлгээ хийх, хувиар	-	Орон зайн мэдээллийн нөхцөл байдлын үнэлгээ хийсэн байна. /100 хувь/	Салбаруудын хөгжлийн бодлогыг орон зайн судалгаанд суурилан тодорхойлох, орон зайн төлөвлөлтийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах тухай” 2025 оны 76 дугаар тогтоолын дагуу холбогдох яам, агентлагууд руу 2025 оны 03/974 тоот албан бичгээр “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах ажлын хэсэг”-г нэр ирүүлэх тухай албан бичгийг хүргүүлсэн. Тус ажлын хэсгийг байгуулах болон ажлын хэсгийн удирдамжийг боловсруулж байна.	10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

#### НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

#### ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Чиг үүргийн хүрээнд гадаад дотоодын сургалтад	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн чиглэлээр сургалтад	-	1	БНХАУ-ын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос зохион байгуулсан “Хятад-ШХАБ-ын Ногоон үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа” сэдэвт семинар болон “Ногоон аж үйлдвэрлэлийн шинэ платформыг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар,	100%

	хамрагдана	хамрагдах		<p>хамтдаа бүтээж, бүс нутгийн хамтын ирээдүйг цогцлоох нь” сэдэвт форумд оролцож, ногоон аж үйлдвэрлэлийн чиглэлээр сургалтад хамрагдав.Семинар, форумын арга хэмжээ БНХАУ-ын Бээжин, Тяньжин хотноо 2025 он 10 дугаар сарын 11-20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ба ЭЗХЯ-наас6 хүний бүрэлдэхүүнтэй оролцов. Семинарын үеэр БНХАУ-ын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Байгалийн Нөөцийн хадгалалт, байгаль орчныг хамгаалах газар, Олон улсын хамтын ажиллагааны төв, Эрчим хүч хэмнэлтийн үндэсний төв, Макро эдийн засгийн судалгааны хүрээлэн, Үндэсний эрчим хүчний удирдах газар, Хөдөө аж ахуйн яам, Бээжингийн Их Сургууль, Цинхуа Их Сургуулийн холбогдох албан тушаалтан, судлаачид илтгэл танилцуулж, Ногоон эдийн засгийн бодлогыг амжилттай хэрэгжүүлж, дэвшилтэт технологийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлэн ажиллаж буй хүнс үйлдвэрлэгч төрийн өмчит “Beijing Shounong Food Group” компани, HUAWEI групп, “Зиа” ногоон эдийн засгийн хөгжлийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй хог, хаягдлын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж Inneng Company, TCL компанийн үйл ажиллагааг танилцуулсан. Семинарт Монгол Улсын ногоон аж үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн өнөөгийн нөхцөл байдал, салбарын стратеги төлөвлөлт, хөгжлийн чиглэл, тулгамдаж буй асуудал болон цаашид БНХАУ-тай хамтын ажиллах боломжуудын талаар илтгэл танилцуулж, БНХАУ-ын ногоон аж үйлдвэрлэлийн хөгжлийн талаар олж авсан мэдлэгийн талаар товч танилцуулга боловсруулсан.</p>	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
--	------------	-----------	--	---	---------------------------------------	--

ХЯНАСАН:

Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Пүрэвдорж Чандмань /...../

Огноо: 2025.12.15

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хүний хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн (Эрүүл мэнд), М Нандинцэцэг /...../

Огноо: 2025.12.15

